

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ- 109

АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨР

- Энэ дүрэм ДБ-ийн сайдын 2002 оны 353 тоот тушаалаар батлагдаж, 2003 оны 02-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.
- Дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд:

/Нэмэлт, өөрчлөлт хийгдээгүй байна/

БҮЛЭГ А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
109.1. Зорилго	2
109.2. Тодорхойлолт	2
109.3. Үндсэн шаардлага	4
БҮЛЭГ Б. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД	4
109.4. Ачаа тээвэр зуучлагчийн аюулгүй байдлын хөтөлбөр	4
109.5. Аюулгүй байдлын арга хэмжээний журам	5
БҮЛЭГ В. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГУУД	6
109.6. Үндсэн үүрэг.....	6
109.7. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах.....	7
109.8. Аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлөгдөх ачаа	7

АЧАА ТЭЭВЭР ЗУУЧЛАГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨР

БҮЛЭГ А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

109.1. Зорилго

Ачаа тээвэр зуучийн байгууллагын Аюулгүй байдлын хөтөлбөрт тавигдах шаардлагыг энэ дүрмээр тогтооно.

109.2. Тодорхойлолт

Агаарын тээвэрлэгч гэж ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн аж ахуйн нэгж, байгууллагыг;

Ачааны агаарын хөлөг гэж зөвхөн бараа болон ачаа тээвэрлэх зориулалт бүхий агаарын хөлгийг;

Ачаа тээврийн зуучлагч гэж ИНД-337-гийн дагуу гэрчилгээжсэн этгээдийг;

Ачааны дагавар бичиг гэж агаарын тээвэрлэгч болон ачаа тээвэр зуучлагчийн хооронд байгуулсан ачаа тээвэрлэлтийн гэрээг;

Аюултай ачаа гэж агаараар тээвэрлэх үед өөрийн шинж чанараараа иргэдийн эрүүл мэнд, эд хөрөнгө болон нислэгийн аюулгүй байдалд үлэмж хор хүргэж болох биет зүйл болон бодисыг;

Буухиа материал гэж яаралтай ачаатай адил нөхцөлөөр тээвэрлэх гар тээш буюу баримт бичиг, жижиг илгээмжийг;

Дамжуулан тээвэрлэлт гэж гадаад улсын нутаг дэвсгэрээс ачуулсан “дамжин өнгөрөх” ба “шилжүүлэх” ачааг Монгол Улсын аль нэг нисэх буудлаас дамжуулан тээвэрлэхийг;

Дамжин өнгөрөх ачааны аюулгүй байдал гэж ачааг, тээвэрлэлт эхэлсэн улсаас хүлээн авах улс хүртэл аюулгүй байдлын шаардлагын дагуу хамгаалахыг;

Тодорхой ачаа гэж “тогтмол харилцагч”-аас хүлээж авсан, аюулгүй байдлын шаардлага хангасан ачааг;

Тогтмол харилцагч гэж :

1/ ачаа тээвэр зуучлалын байгууллагатай тогтмол харилцагч болон агаарын тээвэрлэгчийг,

2/ ачааг эхэлж ачуулсан байгууллагыг;

Тодорхой бус ачаа гэж сэжигтэй зүйл илэрсэн буюу аюулгүй байдлын шаардлага хангаагүй ачааг;

Тогтмол бус харилцагч гэж “тогтмол харилцагч”-аас бусад харилцагчийг ;

Сэжигтэй ачаа гэж “тодорхой” болон “тодорхой бусаас”-аас үл хамааран:

1/ сэжигтэй зүйл гэсэн тэмдэгтэй ачааг;

2/ аюулгүй байдлын үзлэг, шалгалтын үед илэрсэн сэжигтэй зүйлийг;

Хориглосон эд зүйл гэж Агаарын хөлгөөр зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш, ачаанд үзлэг хийх тухай

зааврын 1 дүгээр хавсралтад заагдсан аюултай бодис ба эд зүйлсийг;

Шуудан гэж захидал, ил захидал, сонин, хэвлэмэл богц, загвар богц, илгээмж болон шуудангаар дамжиж буй бусад богцыг тус тус хэлнэ.

109.3. Үндсэн шаардлага

Монгол Улсын нутаг дэвсгэрээс олон улсын зорчигч тээврийн агаарын хөлгөөр ачаа тээвэрлэх байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна:

- 1/ ИНД- 337-ын дагуу гэрчилгээжсэн;
- 2/ энэ дүрмийн шаардлагад нийцсэн аюулгүй байдлын хөтөлбөртэй.

БҮЛЭГ Б. АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГУУД

109.4. Ачаа тээвэр зуучлагчийн аюулгүй байдлын хөтөлбөр

(а) Ачаа тээвэр зуучлалын байгууллага нь энэ дүрмийн шаардлагад нийцсэн аюулгүй байдлын хөтөлбөртэй байна.

Аюулгүй байдлын хөтөлбөрийг хоёр хувь үйлдэж, дараах бичиг баримтыг хавсарган ИНЕГ-т ирүүлнэ:

- 1/ аюулгүй байдлын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулах журам;
- 2/ аюулгүй байдлын хөтөлбөрийн холбогдох заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаар харилцагч болон тээвэрлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээ;
- 3/ аюулгүй байдлын сургалтын журам;

4/ аюулгүй байдлын хөтөлбөр, түүнд холбогдох бусад бичиг баримтад хяналт тавих журам.

5/ энэ дүрмийн 109.5-д заасан журам.

(б) Ачаа тээвэр зуучлалын байгууллагын аюулгүй байдлын хөтөлбөр нь ИНЕГ-аас хүлээн зөвшөөрөхүйц байна.

109.5. Аюулгүй байдлын арга хэмжээний журам

(а) Ачаа тээвэр зуучлалын байгууллага нь хориглосон эд зүйлс ачаагаар дамжин агаарын хөлөгт орохоос урьдчилан сэргийлэх зорилго бүхий аюулгүй байдлын арга хэмжээний журмыг боловсруулна.

(б) Аюулгүй байдлын арга хэмжээг, ачааг агаарын хөлөгт ачихаас өмнө авах ба шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ авна.

(в) Энэ зүйлийн (а)-д заасан журамд дараах зүйлийг тусгасан байна :

1/ "тогтмол харилцагч"-ийн бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах талаар;

2/ "тогтмол харилцагч"-аас хүлээж авсан ачаанд аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийж баталгаажуулсан эсэхийг шалгах талаар;

3/ ачаанд аюулгүй байдлын үзлэг, шалгалт хийснийг гэрчлэх тэмдэг, ачааны дагалдах хуудас болон бусад бичиг баримтыг шалгах талаар;

4/ "тодорхой бус ачаа"-г хүлээж авахаас өмнө түүний дагалдах бичиг баримт, бүртгэлийг шалгах талаар;

5/ "тодорхой" болон "тодорхой бус"- ачааг нийлүүлсэн, эсхүл нэг дор хүлээн авсан тохиолдолд авах арга хэмжээ;

- 6/ ачаанд сэжигтэй зүйл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээ;
- 7/ “тодорхой ачаа”-г хадгалах, хүлээн авах байрны бүтэц, хамгаалалт, түүнд нэвтрэхэд тавих хяналтын талаар;
- 8/ “ тодорхой ачаа”-г авто тээврийн хэрэгслээр тээвэрлэх горим;
- 9/ “тодорхой ачаа” хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн тохиолдолд авах арга хэмжээ;
- 10/ олон улсын нислэгээр тээвэрлэх дамжин өнгөрөх болон шилжүүлэх ачаанд тавигдах аюулгүй байдлын шаардлага;
- 11/ “тодорхой бус ачаа”-нд рентген туяаны аппаратаар болон гараар үзлэг хийх;
- 12/ ачааг агаараар тээвэрлээгүй тохиолдолд түүнд “сэжигтэй” гэсэн тэмдэглэл тавих талаар.

БҮЛЭГ В. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГУУД

109.6. Үндсэн үүрэг

Ачаа тээвэр зуучлалын байгууллага нь:

- 1/ аюулгүй байдлын хөтөлбөрийн хүчин төгөлдөр хувийг байгууллагынхаа үндсэн байршил бүрт хадгална;
- 2/ хөтөлбөрт тусгагдсан бүх журмуудыг мөрдөнө;
- 3/ шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтан болон байгууллагуудад хөтөлбөрийн холбогдох заалтыг хувилж түгээсэн байна;
- 4/ энэ дүрмийн Б бүлэг –т заасан шаардлагуудыг байнга дагаж мөрдөнө.

109.7. Хөтөлбөрт өөрчлөлт оруулах

(а) Хөтөлбөрт оруулах нэмэлт өөрчлөлт нь энэ дүрмийн шаардлагад нийцсэн байна.

(б) Ачаа тээвэр зүүчлалын байгууллага нь ИНЕГ-аас нисэхийн аюулгүй ажиллагааг хангах талаар гаргасан бичиг баримтыг үндэслэн Аюулгүй байдлын хөтөлбөртөө нэмэлт өөрчлөлт оруулна.

109.8. Аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлөгдөх ачаа

(а) Дараах төрлийн ачааг аюулгүй байдлын үзлэгээс чөлөөлнө :

- 1/ захидал (өргөн нь 10 мм-ээс илүүгүй);
- 2/ буухиа зүйлс (өргөн нь 10 мм-ээс илүүгүй);
- 3/ мал, амьтан ;
- 4/ амь тариа, эмнэлгийн тусгай хэрэгсэл, хүний эрхтэн, цусны бөөм ба ижил төрлийн материал;
- 5/ аюулгүй байдлын үзлэг хийснээр чанар нь муудаж болзошгүй эд зүйлс (эдгээр эд зүйлсийн жагсаалтыг ачаа тээвэр зүүчлагч болон агаарын тээвэрлэгчээс гаргаж өгнө);
- 6/ дипломат шуудан:
 - (i) дипломат цүнхэнд байна ;
 - (ii) шинж чанарыг нь тодорхойлсон тэмдэгтэй байна;
 - (iii) дипломат байгууллагын албан ёсны дагавар бичигтэй байна;
- 7/ нууцын зэрэглэлтэй материалууд;
- 8/ үнэт зүйлс (мөнгөн тэмдэгт, эрдэнэс, урлагийн бүтээл г.м.);

9/ шарил (нас барсны гэрчилгээг үндэслэнэ). Хэрэв дагалдах бичиг баримт нь эргэлзээтэй байвал дараах арга хэмжээг авна :

- (i) рентген туяаны аппаратаар үзлэг хийх;
- (ii) дагалдаж яваа хүнийг байлцуулан аюулгүй байдлын ажилтан үзлэг хийх;
- (iii) тээвэрлэхээс татгалзах;
- (iv) чандарын хувьд бусад ачааны адил аюулгүй байдлын үзлэг хийнэ.

* * *